УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/55/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Т.Намжил<br>Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 2
3. Аудитын тайлан ..... 2
3.1 Ерөнхий зүйл ..... 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 13
3.4 Материаллаг байдал ..... 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 16
3.8 Аудитын гол асуудал ..... 16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
4. Аудитын илрүүлэлт ..... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТОГТОХ ТАНАА

2022.02.24 № УА-2022/55/НА-ОТА-тчз
танай ______________-ны №________________-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200198

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 438,658,812.52 | 463,326,402.37 |
| 33 | АВЛАГА | 10,678,639.49 | 11,264,089.94 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 427,980,173.03 | 452,062,312.43 |
| 35100 | Түүхий эд материал | 274,009,037.60 | 274,892,696.60 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 272,975,259.60 | 274,336,518.60 |
| 35130 | Эм боох материал | 1,033,778.00 | 556,178.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| 35400 | Хангамжийн материал | 135,701,135.43 | 157,184,615.83 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,181,200.00 | 1,655,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,989,890.00 | 8,296,215.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,501,500.00 | 1,751,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | |
| 35450 | Барилгын засварын материал | 37,568,554.00 | 52,330,189.00 |
| 35460 | Хүнсний материал | 14,404,201.00 | 21,202,586.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 71,055,790.43 | 71,948,925.83 |
| 35500 | Биологийн хөрөнгө | | |
| 35600 | Мал амьтад | 18,270,000.00 | 19,985,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,814,823,209.07 | 4,855,744,172.79 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,814,823,209.07 | 4,855,744,172.79 |
| 39100 | Газар | | |
| 39200 | Биет хөрөнгө | 4,002,928,409.07 | 4,043,849,372.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,875,431,659.00 | 3,875,431,659.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (267,882,217.64) | (333,698,627.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 76,448,925.00 | 210,428,925.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (71,236,425.00) | (75,586,425.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,805,860,676.07 | 1,869,531,557.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,545,163,004.03) | (1,637,149,050.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 264,288,018.50 | 284,937,918.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (206,591,804.09) | (224,120,124.81) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | | |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | | |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | | |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 180,898,115.60 | 180,898,115.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (176,991,303.34) | (177,741,782.51) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 67,865,769.00 | 70,917,207.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 811,894,800.00 | 811,894,800.00 |
| 39301 | Программ хангамж | 29,857,703.20 | 29,857,703.20 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (29,857,703.20) | (29,857,703.20) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 811,894,800.00 | 811,894,800.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,253,482,021.59 | 5,319,070,575.16 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 523,459.94 | 228,900.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 523,459.94 | 228,900.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,252,958,561.65 | 5,318,841,675.16 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,252,958,561.65 | 5,318,841,675.16 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,315,315,463.70 | 4,315,315,463.70 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (1,411,759,083.29) | (1,345,875,969.78) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,411,759,083.29) | (1,411,759,083.29) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 65,883,113.51 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,349,402,181.24 | 2,349,402,181.24 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,253,482,021.59 | 5,319,070,575.16 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,874,818,670.00 | 3,181,951,579.20 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 94,164,270.00 | 133,432,979.20 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 94,164,270.00 | 133,432,979.20 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 94,164,270.00 | 133,432,979.20 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,888,230.00 | 24,117,460.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,808,700.00 | 19,271,600.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 62,467,340.00 | 90,043,919.20 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,780,654,400.00 | 3,048,518,600.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,762,434,900.00 | 2,873,393,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,762,434,900.00 | 2,873,393,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,219,500.00 | 175,125,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 18,219,500.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 35,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 135,600,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 4,525,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 3,051,698,537.09 | 3,116,068,465.69 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,051,698,537.09 | 3,116,068,465.69 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,744,878,123.66 | 2,952,938,979.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,781,887,007.00 | 1,925,339,016.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,115,608,141.25 | 1,115,763,929.95 |
| 210102 | Нэмэгдэл | 500,487,593.75 | 644,979,627.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,606,915.00 | 68,330,230.00 |
| 210104 | Урамшуулал | 97,184,357.00 | 96,265,228.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 218,856,765.89 | 246,685,943.16 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 149,342,487.64 | 174,233,553.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,819,359.38 | 19,038,792.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,258,482.32 | 15,227,674.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,403,225.26 | 3,542,877.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,033,211.29 | 34,643,045.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 381,973,445.94 | 377,233,147.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,253,985.94 | 21,309,572.06 |
| 210302 | Түлш, халаалт | 331,089,110.00 | 335,029,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,630,350.00 | 20,894,375.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,652,223.00 | 24,900,878.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,167,520.00 | 3,585,510.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,963,400.00 | 9,982,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,695,703.00 | 2,965,468.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 2,572,900.00 | 2,248,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,252,700.00 | 6,119,550.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 50,701,036.00 | 51,955,131.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 758,000.00 | 1,129,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,590,536.00 | 31,311,120.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,352,500.00 | 19,514,711.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,836,000.00 | 41,249,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,836,000.00 | 41,249,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,320,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,320,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,616,182.00 | 9,274,049.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,736,956.00 | 2,269,356.00 |
| 210803 | Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал | 2,000,000.00 | 6,019,440.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 106,000.00 | 102,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 368,500.00 | 511,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 371,726.00 | 371,753.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 279,035,463.83 | 276,301,815.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 87,525,646.80 | 95,870,559.60 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 191,509,817.03 | 180,431,255.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 306,820,413.43 | 163,129,486.39 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 270,357,086.00 | 141,089,138.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 111,253,870.00 | 11,978,486.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 156,401,322.00 | 125,812,452.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,701,894.00 | 3,298,200.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,463,327.43 | 22,040,348.39 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(176,879,867.09)** | **65,883,113.51** |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(176,879,867.09)** | **65,883,113.51** |

2.3 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,833,979,500.00 | 3,124,235,397.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 32,717,204.00 | 43,389,060.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 32,717,204.00 | 43,389,060.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 32,717,204.00 | 43,389,060.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,888,230.00 | 24,117,460.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,828,974.00 | 19,271,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,801,262,296.00 | 3,080,846,337.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,762,434,900.00 | 2,873,393,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,762,434,900.00 | 2,873,393,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,219,500.00 | 175,125,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 18,219,500.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 35,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 135,600,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 4,525,000.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 20,607,896.00 | 32,327,737.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,833,979,500.00 | 2,955,680,497.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,833,979,500.00 | 2,955,680,497.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,507,413,690.57 | 2,760,014,230.61 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,775,022,662.00 | 1,925,339,016.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,108,743,796.25 | 1,115,763,929.95 |
| 210102 | Нэмэгдэл | 500,487,593.75 | 644,979,627.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,606,915.00 | 68,330,230.00 |
| 210104 | Урамшуулал | 97,184,357.00 | 96,265,228.95 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 225,072,288.57 | 246,645,442.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 155,558,010.32 | 174,193,052.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,819,359.38 | 19,038,792.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,258,482.32 | 15,227,674.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,403,225.26 | 3,542,877.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,033,211.29 | 34,643,045.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 393,956,618.00 | 377,302,015.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,185,118.00 | 21,378,440.00 |
| 210302 | Түлш, халаалт | 343,141,150.00 | 335,029,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,630,350.00 | 20,894,375.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,005,175.00 | 18,478,228.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 3,001,400.00 | 4,332,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,742,450.00 | 4,379,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,696,425.00 | 2,965,468.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 4,371,400.00 | 2,567,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,193,500.00 | 4,232,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,213,800.00 | 55,741,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,183,600.00 | 651,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,510,200.00 | 41,499,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,520,000.00 | 13,590,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,969,700.00 | 54,628,875.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 2,969,700.00 | 54,128,875.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,320,000.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,320,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,616,182.00 | 9,186,049.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,736,956.00 | 2,269,356.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 6,019,440.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 106,000.00 | 102,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 368,500.00 | 423,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 371,726.00 | 371,753.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,237,265.00 | 72,693,605.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 40,237,265.00 | 72,693,605.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 326,565,809.43 | 195,666,266.39 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 290,102,482.00 | 172,681,875.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж | 20,607,896.00 | 32,327,737.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 111,253,870.00 | 11,978,486.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 156,401,322.00 | 125,812,452.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,839,394.00 | 2,563,200.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,463,327.43 | 22,984,391.39 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | 168,554,900.00 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | 168,554,900.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 0.00 | 168,554,900.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 168,554,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 222001 | Тоног төхөөрөмж | | 45,320,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 88,660,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 34,574,900.00 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | - | (168,554,900.00) |
| VII | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | - | |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | - | |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,315,315,463.70 | 2,349,505,774.34 | (1,234,982,809.30) | 5,429,838,428.74 |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | - | - | - | - |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 4,315,315,463.70 | 2,349,505,774.34 | (1,234,982,809.30) | 5,429,838,428.74 |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | 0 | - | 0 | - |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 0 | 0 | 0 | - |
| 6 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | 0 | 0 | 0 | - |
| 7 | **Өмчид гарсан өөрчлөлт** | | | | |
| 8 | **Зарласан ногдол ашиг** | | | | |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | - | 0 | (176,879,867.09) | (176,879,867.09) |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,315,315,463.70 | 2,349,402,181.24 | (1,411,759,083.29) | 5,252,958,561.65 |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 4,315,315,463.70 | 2,349,402,181.24 | (1,411,759,083.29) | 5,252,958,561.65 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | - | 0 | - |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 4,315,315,463.70 | 2,349,402,181.24 | (1411759083.29) | 5,252,958,561.65 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 18 | Зарласан ногдол ашиг | | | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 65,883,113.51 | 65,883,113.51 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,315,315,463.70 | 2,349,402,181.24 | (1,345,875,969.78) | 5,318,841,675.16 |

2.5 **Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,920,643,600.00 | 2,897,262,311.61 | 23,381,288.39 | 99.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,920,643,600.00 | 2,897,262,311.61 | 23,381,288.39 | 99.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,781,289,400.00 | 2,757,008,173.61 | 24,281,226.39 | 99.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,922,760,800.00 | 1,921,374,259.00 | 1,386,541.00 | 99.93 |
| 210101 | Үндсэн цалин | 1,112,070,700.00 | 1,111,799,172.95 | 271,527.05 | 99.98 |
| 210102 | Нэмэгдэл | 644,898,700.00 | 644,979,627.10 | (80,927.10) | 100.01 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,607,000.00 | 68,330,230.00 | 276,770.00 | 99.60 |
| 210104 | Урамшуулал | 97,184,400.00 | 96,265,228.95 | 919,171.05 | 99.05 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 258,101,700.00 | 246,110,442.61 | 11,991,257.39 | 95.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 187,075,300.00 | 173,658,052.56 | 13,417,247.44 | 92.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,756,600.00 | 19,038,792.81 | (1,282,192.81) | 107.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,205,300.00 | 15,227,674.09 | (1,022,374.09) | 107.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,551,300.00 | 3,542,877.49 | 8,422.51 | 99.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,513,200.00 | 34,643,045.66 | 870,154.34 | 97.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 386,592,700.00 | 377,302,015.00 | 9,290,685.00 | 97.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,167,100.00 | 21,378,440.00 | 7,788,660.00 | 73.30 |
| 210302 | Түлш, халаалт | 335,025,900.00 | 335,029,200.00 | (3,300.00) | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,399,700.00 | 20,894,375.00 | 1,505,325.00 | 93.28 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,579,800.00 | 15,575,528.00 | 4,272.00 | 99.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,431,600.00 | 2,930,010.00 | (498,410.00) | 120.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,725,100.00 | 2,879,950.00 | (154,850.00) | 105.68 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,447,600.00 | 2,965,468.00 | 482,132.00 | 86.02 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 3,152,400.00 | 2,567,300.00 | 585,100.00 | 81.44 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,823,100.00 | 4,232,800.00 | (409,700.00) | 110.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 47,130,500.00 | 46,876,000.00 | 254,500.00 | 99.46 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 652,600.00 | 651,700.00 | 900.00 | 99.86 |
| 210502 | Хоол, хүнс | 41,192,100.00 | 40,974,300.00 | 217,800.00 | 99.47 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,285,800.00 | 5,250,000.00 | 35,800.00 | 99.32 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 89,956,000.00 | 89,203,775.00 | 752,225.00 | 99.16 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,700,000.00 | 19,975,000.00 | 725,000.00 | 96.50 |
| 210602 | Тавилга | 15,100,000.00 | 15,099,900.00 | 100.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | | | |
| 210604 | Урсгал засвар | 54,156,000.00 | 54,128,875.00 | 27,125.00 | 99.95 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | | | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,775,700.00 | 9,186,049.00 | 589,651.00 | 93.97 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,346,400.00 | 2,269,356.00 | 77,044.00 | 96.72 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6,019,500.00 | 6,019,440.00 | 60.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 240,000.00 | - | 240,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,000.00 | 102,000.00 | 82,000.00 | 55.43 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | - | 132,000.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 440,900.00 | 423,500.00 | 17,400.00 | 96.05 |
| 210807 | Газрын төлбөр | 412,900.00 | 371,753.00 | 41,147.00 | 90.03 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 51,392,200.00 | 51,380,105.00 | 12,095.00 | 99.98 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 51,392,200.00 | 51,380,105.00 | 12,095.00 | 99.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 139,354,200.00 | 140,254,138.00 | (899,938.00) | 100.65 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 139,354,200.00 | 140,254,138.00 | (899,938.00) | 100.65 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,978,500.00 | 11,978,486.00 | 14.00 | 100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 125,812,500.00 | 125,812,452.00 | 48.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,563,200.00 | 2,463,200.00 | (900,000.00) | 157.57 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,920,643,600.00 | 2,916,782,660.00 | 3,860,940.00 | 99.87 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,873,393,600.00 | 2,873,393,600.00 | - | 100.00 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,873,393,600.00 | 2,873,393,600.00 | - | 100.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 47,250,000.00 | 43,389,060.00 | 3,860,940.00 | 91.83 |
| 350001 | **Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих** | 24,650,000.00 | 24,117,460.00 | 532,540.00 | 97.84 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,600,000.00 | 19,271,600.00 | 3,328,400.00 | 85.27 |

## 2.6 **Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 39,525,000.00 | 37,680,957.00 | 1,844,043.00 | 95.33 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 39,525,000.00 | 37,680,957.00 | 1,844,043.00 | 95.33 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 38,525,000.00 | 37,580,957.00 | 944,043.00 | 97.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,965,000.00 | 3,964,757.00 | 243.00 | 99.99 |
| 210101 | Үндсэн цалин | 3,965,000.00 | 3,964,757.00 | 243.00 | 99.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 535,000.00 | 535,000.00 | - | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 535,000.00 | 535,000.00 | - | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,913,300.00 | 2,902,700.00 | 10,600.00 | 99.64 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,413,300.00 | 1,402,700.00 | 10,600.00 | 99.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 8,865,000.00 | 8,865,000.00 | - | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 525,000.00 | 525,000.00 | - | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,340,000.00 | 8,340,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,246,700.00 | 21,313,500.00 | 933,200.00 | 95.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,246,700.00 | 21,313,500.00 | 933,200.00 | 95.81 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 100,000.00 | 900,000.00 | 10.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 100,000.00 | 900,000.00 | 10.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 100,000.00 | 900,000.00 | 10.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 135,600,000.00 | 133,980,000.00 | 1,620,000.00 | 98.81 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 46,000,000.00 | 45,320,000.00 | 680,000.00 | 98.52 |
| 223001 | Бусад хөрөнгө | 89,600,000.00 | 88,660,000.00 | 940,000.00 | 98.95 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 175,125,000.00 | 175,125,000.00 | - | 100.00 |
| **31** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 175,125,000.00 | 175,125,000.00 | - | 100.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,000,000.00 | 35,000,000.00 | - | 100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 135,600,000.00 | 135,600,000.00 | - | 100.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,525,000.00 | 4,525,000.00 | - | 100.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улаангом политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом политехник коллеж нь Улаангом политехник коллеж нь иргэдэд мэргэжлийн боловсролын сургалтын үйлчилгээ үзүүлж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом политехник коллеж 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Улаангом политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,051,698.5 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 15,258.5 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,116,068.4 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 15,580.3 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 12,464.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом политехник коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,588.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 10,678.63 | 11,264.08 | 585.45 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 427,980.17 | 452,062.31 | 24,082.14 |
| Үндсэн хөрөнгө | 4,814,823.21 | 4,855,744.17 | 40,920.96 |
| **Нийт хөрөнгө** | 5,253,482.01 | 5,319,070.56 | 65,588.55 |
| Өр төлбөр | 523.45 | 228.9 | 294.55 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 5,252,958.56 | 5,318,841.67 | 65,883.11 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 5,253,482.01 | 5,319,070.56 | 65,588.55 |

Авлага дансны үлдэгдэл 11264.1 мянган төгрөг болж 585.4 мянган төгрөгөөр өссөн нь төвлөрүүлэх шилжүүлгээс буцааж авах авлаг үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 452,062.3 мянган төгрөг болж өссөн 24,082.1 мянган төгрөгөөр өссөн нь барилга засварын материал, хүнсний материалын үлдэгдэл өссөнөөс голчлон шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг 2022 оны сургалтын болон бусад үйл ажиллагаанд зарцуулна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,855,744.2 мянган төгрөг болж 40,920.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалт, хандив, төсвийн хөрөнгөөр машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 168,554.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 52,797.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 228.9 мянган төгрөг болж 294.5 мянган төгрөгөөр буурсан нь цахилгаан, ХАОАТ-н өр төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,318,741.6 мянган төгрөг болж 65,883.1 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энд автомашин, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 307,132.9 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 64,369.9 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс зардал өсөхөд цалин, НДШ, эд хогшил, урсгал засварын зардлууд голчлон нөлөөлсөн байна. Энэ нь багш нарын илүү цагийн нэмэгдэл цалин нэмэгдүүлсэн, эд хогшил худалдан авсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,432,423.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,432,423.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 511,779.6 мянган төгрөгөөр бууруулж 2,920,643.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг хүргүүлэхдээ ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлсэн, 300 ортой дотуур байр ашиглалтад орохтой холбоотой тогтмол зардлыг нэмэгдүүлж хүргүүлсэн нь хасагдаж батлагдаж ирсэнтэй холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,920,643.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,873,393.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,250.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,873,393.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 43,389.06 мянган төгрөг, нийт 2,916,782.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,897,262.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 19520.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,897,262.3 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 35,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 135,600.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,525.0 мянга, нийт 175,125.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 37,680.9 мянга, хөрөнгийн зардалд 133,980.0 мянга, нийт 171,660.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 3,464.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэл тайланд анхаарч шалгах дараах асуудал байна.

1. Улаангом политехник коллежийн захирал Д.Баттогтох нь 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаалаар чөлөөлөгдөж Нийслэлийн захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзэн ажилд нь эргүүлэн томилж ажиллаагүй хугацааны цалинг олгож нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн бичих шийдвэр гаргасан байна. Шүүхийн шийдвэрийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Б/21 тоот тушаалаар ажилд эргүүлэн томилсон байна. 2021 онд ажиллаагүй хугацааны цалинд 18,708.9 мянган төгрөг авсан байна. /Энэ асуудал нь буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төрийг хохиролгүй болгуулах/
2. Улаангом политехник коллежийн захирал Д.Баттогтох нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүү, хөрөнгө оруулалтын газарт Боловсролын тухай хуулийн 43.1.7-д заасан тэтгэлэг авах тухай хувийн хүсэлт гаргасны дагуу байгууллагын төсвийн хуваарьт нь өөрчлөлт орж батлагдаж ирсний дагуу 5,974.9 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны дэмжлэг авсан байна. Энэ асуудлыг ҮАГ-ын нэгтгэл тайланд тусгуулахаар албан тоот хүргүүлэхээр тогтов.

### 3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом политехник коллежийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 140, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын батлагдсан бүтэц орон тоогоор ажиллах зөвлөмж өгсний хэрэгжүүлэн биелэлтийг гарган ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,268.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулга хийлгэв. Үүнд:

### 4.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг зөрчин тооцоо үүсгэхгүйгээр 2,363.2 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн байна.
2. Элэгдлийн зардлыг 6,905.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаангом политехник коллеж | 2 | 9,268.8 | 2 | 9,268.8 | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 22-ны өдөр